



"ХИШИГ-УУЛ"
ХУВЬЦААТ КОМПАНИ

Улаанбаатар хот. Багануур дүүрэг
Нацагдоржийн гудамж. Ш/Х-228
Утас: 9911-5690, 9999-9498
E-mail: Khishig-Uul@yahoo.com

2025.02.10 № 06

танай _____ -ны № _____ -т

Г Брокер, дилерийн компаниудад Г

"Хишиг-Уул" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь 2025 оны 2 дугаар сарын 07-ны өдрийн ээлжит бус хурлаараа Компанийн тухай хуулийн 53.2 дахь хэсэгт заасан "хувьцаа эзэмшигчдийн өөрийн эзэмшлийн хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрх"-ийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн тул үүнтэй холбоотой баримт бичгийг хавсралтаар хүргүүлж байгааг хүлээн авна уу.

Гүйцэтгэх
захирал



Я.Нэргүй

**“ХИШИГ-УУЛ” ХК-ИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ**

2025 оны 02 дугаар сарын 07

№ 01

Улаанбаатар хот

*“Хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж
авахыг компаниас шаардах эрх үүссэн тухай”*

Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4 дэх хэсгийг удирдлага болгож, Хишиг-Уул ХК (цаашид “Компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр хуралдаж, дараах тогтоолыг баталж байна:

ТОГТООХ НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигч Я.Нэргүй нь Компанийн нийт гаргасан хувьцааны 34 хувь буюу хяналтын багцыг нээлттэй дуудлага худалдаагаар дамжуулан 2024 оны 11 сарын 22-ны өдөр худалдан авч, улмаар 2024 оны 12 сарын 31-ний өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г олгосонтой холбоотойгоор Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлийн дагуу Компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүсэж буй тул энэхүү эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг Хавсралт №1-д зааснаар баталсугай.
3. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г Я.Нэргүйд олгосон өдөр буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс тархалтыг мэдээг гаргуулан авахыг Гүйцэтгэх захирал Я.Нэргүйд даалгасугай.
4. Компанийн эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнийг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж ХК-аас ирүүлсэн 03/107 тоот албан бичигт дурдсаны дагуу 4,393.90 төгрөг байхаар тогтоосугай.

5. Компанийн хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-д 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
6. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах сүүлийн хугацааг мэдэгдлийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн өдөр буюу 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хойш ажлын 30 хоногийг дуустал байхаар тогтоосугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй тухай мэдэгдлийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГОНГОР

"ХИШИГ-УУЛ" ХК-ийн

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын тэмдэглэл

Хурал товлогдсон өдөр буюу 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 10:00 цагт Монгол Улс, Улаанбаатар хот, Багануур дүүрэг, Нацагдоржийн гудамж, "Хишиг-Уул" ХК (цаашид "Компани" гэх)-н байранд хуралдлаа. Хуралд гишүүдийн дийлэнх олонх буюу 6 гишүүн оролцсоноор 66.7 хувийн хүчин төгөлдөр ирцтэйгээр хуралдлаа.

Хуралд оролцсон гишүүд:

1. Я.Нэргүй
2. Ц.Роза
3. Д.Гонгор
4. Д.Сэржамц
5. Ж.Ганболд
6. Н.Сүлд-Очир нар оролцов.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлуудыг танилцууллаа:

1. Компанийн хувьца эзэмшигч Я.Нэргүй нь Компанийн гаргасан хувьцааны 34 хувь буюу хяналтын багцыг нээлттэй дуудлага худалдаагаар дамжуулан худалдан авсантай холбогдуулан бусад хувьцаа эзэмшигчдийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай;
2. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг батлах тухай;
3. Компанийн эргүүлэн худалдаж авах нэгж хувьцааны үнийг тогтоох тухай;
4. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах өдрийг тогтоох тухай;

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Юун түрүүнд, Компанийн хувьцаа эзэмшигч Я.Нэргүй миний бие Компанийн нийт гаргасан хувьцааны нийслэлийн мэдэлд байсан 34 хувь буюу хяналтын багцыг нээлттэй дуудлага худалдаанд оролцон худалдан авсантай холбогдуулан Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралдуулах санал, шаардлагыг гаргасан. 2024 оны 11 сарын 22-ны өдрийн нээлттэй дуудлага худалдаа нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 102 дугаар тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын "Дуудлагын худалдаа дахин явуулах тухай" 2020 оны 21 дүгээр тогтоолын дагуу зохион байгуулагдаж, миний бие 608,400,000 төгрөгөөр нийт 34 хувийн хувьцааг худалдан авахаар шалгарсан. Ингээд тус өдөр хувьцаа худалдах, худалдан авах гэрээ байгуулагдаж, улмаар 2024 оны 12 сарын 31-ний өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссоос "Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ"-г олгосноор миний бие Компанийн нийт 64,3 хувийн хувьцаа эзэмшигч

болсон байна. Компанийн хяналтын багцыг хувьцчилж авснаар Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн дагуу бусад хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй болох юм. Энэ шаардах эрхийг хэрхэн хэрэгжүүлэх тухай хэлэлцэн батлах шаардлагатай болоод байна. Үүний тулд эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг батлах, бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх, эргүүлээд шаардлага хүлээн авах өдрийг тодорхой болгох, тархалтын мэдээ гаргуулж авах өдрийг тогтоох шаардлагатай байна.

ТУЗ-ийн дарга Д.Гонгор: 2024 оны 12 сарын 31-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд шаардах эрх үүссэн гэж үзвэл үүнээс ажлын 30 хоногийг тооцоод үзэхээр 2025 оны 2 сарын 12-ны өдрөөс өмнө мэдэгдлээ хүргүүлэх шаардлагатай юм байна. Мэдэгдлийг 2025 оны 2 сарын 12-ны өдрийн дотор мэдэгдэх санал гаргаж байна.

ТУЗ-ийн гишүүн Н.Сүлд-Оргил: Дэмжиж байна.

ТУЗ-ийн гишүүн Ц.Роза: Нэгж хувьцааны сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг тодорхойлж өгөх хүсэлтийг Хөрөнгийн бирж рүү 2025 оны 2 дугаар сарын 5-ны өдөр хүргүүлээд 2025 оны 2 сарын 7-ны өдөр хариуг нь авсан. Хөрөнгийн бирж нэгж хувьцааны сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг 4,393.90 төгрөг гэж тогтоосон. Үүний дагуу эргүүлэн худалдах авах нэгж хувьцааны үнийг тогтоох саналтай байна.

ТУЗ-ийн гишүүн Я.Нэргүй: Хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүдийн 100 хувийн саналаар дараах асуудлыг шийдвэрлэлээ.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Компанийн хувьцаа эзэмшигч Я.Нэргүй нь Компанийн нийт гаргасан хувьцааны 34 хувь буюу хяналтын багцыг нээлттэй дуудлага худалдаагаар дамжуулан 2024 оны 11 сарын 22-ны өдөр худалдан авч, улмаар 2024 оны 12 сарын 31-ний өдөр Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г олгосонтой холбоотойгоор Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлийн дагуу Компанийн бусад хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүсэж буй тул энэхүү эрхийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсүгэй.
2. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журмыг баталсугай.
3. Өөрийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг Нийслэлийн өмч хувьчлах комиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г Я.Нэргүйд олгосон өдөр буюу 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тогтоож, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс тархалтыг мэдээг гаргуулан авахыг Гүйцэтгэх захирал Я.Нэргүйд даалгасугай.
4. Компанийн эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнийг 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж ХК-аас ирүүлсэн 03/107 тоот албан бичигт дурдсаны дагуу 4,393.90 төгрөг байхаар тогтоосугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдэд хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй тухай шийдвэрийг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-д 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор зохих баримт бичгийн хамт хүргүүлсүгэй.
6. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авах сүүлийн хугацааг мэдэгдлийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн өдөр буюу 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс хойш ажлын 30 хоногийг дуустал байхаар тогтоосугай.
7. Компанийн хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй тухай мэдэгдлийг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдрийн дотор өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн цахим хуудсаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэхийг Компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Батчимэгт даалгасугай.

Дээрх асуудлыг хэлэлцэж дуусаад хурлын дарга хурал хаасныг мэдэгдэв.

Хурал 2025 оны 02 дугаар сарын 7-ны өдрийн 11:30 цагт хаав.

Хурлын тэмдэглэл хөтөлсөн нарийн бичиг:

/С.БАТЧИМЭГ/

- | | | |
|-------------------------|--|-------------|
| 1. ТУЗ-ийн дарга..... | | Д.Гонгор |
| 2. ТУЗ-ийн гишүүн | | Я.Нэргүй |
| 3. ТУЗ-ийн гишүүн..... | | Ц.Роза |
| 4. ТУЗ-ийн гишүүн..... | | Д.Сэржамц |
| 5. ТУЗ-ийн гишүүн..... | | Ж.Ганболд |
| 6. ТУЗ-ийн гишүүн..... | | Н.Сүлд-Очир |

"ХИШИГ-УУЛ" ХК-ийн

Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам (цаашид **"Журам"** гэх)-аар Хишиг-Уул ХК (цаашид **"Компани"** гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг Компани эргүүлэн худалдан авах харилцааг зохицуулна.
- 1.2. Компанийн хувьцаа эзэмшигч Я.Нэргүй нь Компанийн нийслэлийн өмчийн мэдэлд байсан 34 хувийн хувьцаа буюу хяналтын багцыг хувьчлан авснаар Компанийн тухай хууль (цаашид **"КтХ"** гэх)-ийн 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсэгт заасны дагуу бусад энгийн хувьцаа эзэмшигчдэд (цаашид **"Бусад хувьцаа эзэмшигчид"** гэх) хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүссэн болно.
- 1.3. Бусад хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг шаардах эрх үүссэн өдөр буюу Нийслэлийн өмч хувьчлах комиссоос **"Өмчлөгчийн эрхийн гэрчилгээг"** Я.Нэргүйд олгосон 2024 оны 12 сарын 31-ний өдрөөр тасалбар болгон үнэт цаас эзэмшигчдийн бүртгэлд байсан мэдээллийг үндэслэн гаргана.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг

- 2.1. Бусад хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа эргүүлж худалдан авах шаардлагаа Журмын 3.1-д заасан мэдэгдлийг Компаниас хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид **"ТУЗ"** гэх)-д бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргана.
- 2.2. Бусад хувьцаа эзэмшигчдийн Компанид ирүүлэх шаардлагадаа эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эргүүлэн худалдаж авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрлийг заасан байна.

Гурав. Компанийн эрх, үүрэг

- 3.1. Компанийн ТУЗ нь шаардах эрх үүссэх талаарх мэдэгдлийг КтХ-д заасан журам болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмын дагуу шаардах эрх үүссэн өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор Бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.
- 3.2. Компани нь Бусад хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх мэдэгдэлдээ дараахыг тусгасан байна.
 - 3.2.1. Эргүүлэн худалдан авах нийт хувьцааны тоо;

- 3.2.2. Эргүүлэн худалдан авах нэгж хувьцааны үнэ;
 - 3.2.3. Бусад хувьцаа эзэмшигчдийн шаардлага гаргах хугацаа;
 - 3.2.4. Төлбөр төлөх хугацаа;
 - 3.2.5. Компанийн шаардлага хүлээн авах хаяг, цахим шуудан.
- 3.3. Компанийн ТУЗ нь КтХ-ийн 55 дугаар зүйлийн 55.8 дахь хэсэгт “Нийгэд худалдагдаж байгаа хувьцаа болон бусад үнэт цаасны зах зээлийн үнийг тогтоохдоо үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын болон бусад арилжааны албан ёсны мэдээнд тусгасан сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг харгалзана” гэж заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хувьцааг худалдаж авах зах зээлийн үнийг тодорхойлж, тус худалдан авах үнийг Бусад хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх мэдэгдэлд заасан байна.
- 3.4. Компани нь Бусад хувьцаа эзэмшигчдийн шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор эргүүлэн худалдаж авах эрхийн тухай мэдээлсэн мэдэгдэлд дурдсан үнээр хувьцааг худалдан авах, эсхүл хувьцаа эзэмшигчийн хувьцааг эргүүлэн худалдаж авахаас татгалзсан үндэслэлээ хувьцаа эзэмшигчид мэдэгдэнэ.

**Дөрөв. Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг
шаардах эрхийг хэрэгжүүлэх журам**

- 4.1. Бусад хувьцаа эзэмшигчид нь энэхүү Журамд заасны дагуу ажлын 30 өдрийн дотор шаардах эрхээ хэрэгжүүлэх шаардлагыг ирүүлээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтайд тооцох ба шаардлага ирүүлээгүй хувьцаа эзэмшигч Компанийн эсрэг гомдол гаргах эрхгүй байна.
- 4.2. Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардсан мэдэгдлийг Компанийн ТУЗ-ийн Нарийн бичгийн дарга болон Гүйцэтгэх захирал хүлээн авч тухай бүр ТУЗ-ийн даргад мэдэгдэж ажиллах бөгөөд Гүйцэтгэх захирал нь шаардлага ирүүлсэн хувьцаа эзэмшигчидтэй холбогдох хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, эрх шилжүүлэх гэрээг байгуулж, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын Хөрөнгийн Бирж ХК-д хууль, тогтоомжид заасан хугацаанд тус тус бүртгүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллана.



“Хишиг-Уул” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх мэдэгдэл

2025 оны 2 сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

Хишиг-Уул ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигч Я.Нэргүй нь 2024 оны 11 сарын 22-ны өдөр Компанийн Нийслэлийн эзэмшилд байсан 34 хувийн хувьцааг нээлттэй дуудлага худалдаагаар худалдан авснаар 2024 оны 12 сарын 31-ний өдөр Нийслэлийн өмч хувьчлах коммиссоос “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г Я.Нэргүйд олгосон. Ийнхүү Компанийн тухай хуулийн 53.2 дахь хэсэгт заасанчлан Я.Нэргүй нь төрийн өмчийн эзэмшилд байсан компанийн хувьцааны хяналтын багцыг хувьчлан авсан тул бусад хувьцаа эзэмшигч Та бүхэнд хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрх үүсээд байна. Үүнтэй холбогдуулан 2025 оны 2 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар хувьцаа эзэмшигчдийн энэхүү шаардах эрхийг хэрэгжүүлэх тухай шийдвэр гаргасан. Иймд Компанийн хувьцаа эзэмшигч Та Компанийн тухай хуулийн 53.2 дахь хэсэгт заасныг үндэслэн, өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхтэй болохыг Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасны дагуу Танд мэдэгдэж байна.

Хувьцаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигч:

Хишиг-Уул ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь хувьцаа эзэмшлийн тархалтын мэдээг гаргах өдрийг хувьцаа эзэмшигч Я.Нэргүйд “Өмчлөгчийн эрхийг гэрчилгээ”-г олгосон 2024 оны 12 сарын 31-ний өдөр байхаар тогтоосон тул Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөс тус өдрийг тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад багтсан хувьцаа эзэмшигчид нь хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй болно.

Хувьцаа эргүүлэн худалдан авах үнэ:

Хишиг-Уул ХК нь 2025 оны 2 сарын 5-ны өдөр Компанийн тухай хуулийн 55.8 дахь хэсэгт заасны дагуу хувьцааны сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг тодорхойлуулахаар Монголын Хөрөнгийн Бирж ХК-д хүсэлт хүргүүлсэн ба Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2025 оны 2 сарын 7-ны өдрийн 03/107 албан бичгээр Хишиг-Уул ХК-ийн хувьцааны сүүлийн зургаан сарын жигнэсэн дундаж ханшийг 4,393.90 төгрөг гэж гаргасан болно. Иймд нэг хувьцаа худалдан авах үнийг үүн дээр үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 2 сарын 7-ны өдрийн тогтоолоор 4,393.90 төгрөг байхаар тогтоосон.

Шаардах эрхийг хэрэгжүүлэх журам:

Бичгээр шаардлага ирүүлэх: Хувьцаа эзэмшигчийн бичгээр ирүүлсэн хүсэлтийг Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ардчиллын өргөө, 6 давхар | Ш/х-371, Сноу Хилл Консалтанси ХХН-ийн байранд хүлээн авна.

Бүрдүүлэх баримт бичиг	
Иргэн	Хүсэлт: Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эргүүлэн худалдаж авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрлийг заасан, гарын үсэг зурсан байна.
	Иргэний үнэмлэхийн хуулбар эсхүл иргэний үнэмлэхийн лавлагаа
Хуулийн этгээд	Хүсэлт: Хуулийн этгээдийн нэр, албан ёсны хаяг болон эргүүлэн худалдаж авахыг шаардаж байгаа хувьцааны тоо, төрлийг заасан, эрх бүхий этгээд гарын үсэг зурсан, хуулийн этгээдийн тамга, тэмдэг дарсан байна.
	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, шууд төлөөлөх эрх бүхий этгээд биш бол итгэмжлэлийн хамт

Шаардлага хүлээн авах эцсийн хугацаа: Энэхүү мэдэгдлийн өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор буюу 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийг дуустал хүсэлтийг хүлээн авна.

Шаардлагыг шийдвэрлэх ажиллагаа: Эргүүлэн худалдан авахыг шаардсан хувьцаанд ногдох төлбөрийг шаардлага хүлээн авах эцсийн хугацаа дуусгавар болсноос хойш ажлын 30 өдрийн дотор мөнгөн хэлбэрээр тухайн хувьцаа эзэмшигчийн Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд шилжүүлнэ.

Тодруулга, мэдээлэл авах:

Цахим шуудан: anudari@snowhill.mn

Утас: +(976)-8809 8193, 94012256

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Д.ГОНГОР



НИЙСЛЭЛИЙН
ӨМЧ ХУВЬЧЛАХ КОМИССЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 30 өдөр

Дугаар 06.

Улаанбаатар хот

Г Өмчлөгчийн эрх олгох тухай 7

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2016 оны 102 дугаар тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2017 оны 09 дүгээр тогтоол, 2017 оны 17, 2020 оны 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн Өмч хувьчлах комиссоос ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Хишиг уул" хувьцаат компанийн нийслэлийн мэдлийн 34 хувь буюу 295 206 (хоёр зуун ерэн таван мянга хоёр зуун зургаан) ширхэг хувьцааг нээлттэй дуудлагын худалдаагаар хувьчилж авсан иргэн Я.Нэргүй нь хувьцааны үнэ 608,400,000 (зургаан зуун найман сая дөрвөн зуун мянга) төгрөгийг хуульд заасан хугацаанд бүрэн төлсөн тул тус хувьцааны өмчлөгчийн эрхийг шилжүүлэн олгосугай.

2. Шинэ өмчлөгчид "Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ" олгохыг Нийслэлийн Өмч хувьчлах комиссын нарийн бичгийн дарга (В.Оюумаа)-д үүрэг болгосугай.

3. Хувьчлагдсан хувьцааг иргэн Я.Нэргүйд хүлээлгэн өгч, зохих журмын дагуу нийслэлийн өмчийн бүртгэлээс хасахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар /В.Оюумаа/-т зөвшөөрсүгэй.

4. Хувьчилсан тухай тайланг 2025 оны 2 дугаар улиралд багтаан Нийслэлийн Өмч хувьчлах комиссын хурлаар хэлэлцүүлж, батлуулахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (С.Сэржжаргал)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
ӨМЧ ХУВЬЧЛАХ КОМИССЫН ДАРГА



Н.Нямбаатар Х.НЯМБААТАР

ӨМЧ ХУВЬЧЛАХ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

В.Оюумаа В.ОЮУМАА

ӨМЧЛӨГЧИЙН ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭ

№ 02/2024

ЯДАМ ОВОГТОЙ НЭРГҮЙ

(иргэн, аж ахуйн нэгжийн нэр)

Регистрийн дугаар: ГЭ57080216

УЛААНБААТАР

БАГАНУУР

Аймаг, нийслэл сум, дүүрэг

**НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН 2016 ОНЫ
102 ДУГААР ТОГТООЛ, НИЙСЛЭЛИЙН ӨМЧ ХУВЬЧЛАХ КОМИССЫН
2017 ОНЫ 09, 17 ДУГААР ТОГТООЛ, 2020 ОНЫ 21 ДҮГЭЭР
ТОГТООЛООР**

/Нээлттэй дуудлагын худалдаагаар/

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын Хурлын танхим

(худалдаа явагдсан газар)

Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 02 дугаар тогтоолоор:

Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байрлах "Хишиг Уул" хувьцаат компанийн нийслэлийн мэдлийн 34 хувь буюу 295 206 ширхэг хувьцааг 608,400,000 (зургаан зуун найман сая дөрвөн зуун мянга) төгрөгөөр худалдан авч, үнийг бүрэн төлсөн тул 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн өмчлөгч болсныг гэрчлэв.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД
УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ
ӨМЧ ХУВЬЧЛАХ КОМИССЫН ДАРГА

Х. Нямбаатар
Х. НЯМБААТАР

ӨМЧ ХУВЬЧЛАХ КОМИССЫН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

В. Оюумаа
В. ОЮУМАА

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

**“ХИШИГ УУЛ” ХХК-ИЙН НИЙСЛЭЛИЙН МЭДЛИЙН
34 ХУВЬ БУЮУ 295 206 ШИРХЭГ ХУВЬЦААГ
ХҮЛЭЭЛГЭЖ ӨГСӨН ТУХАЙ**

2025.01.02

Улаанбаатар хот

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 102 дугаар тогтоол, Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2020 оны 21 дугаар тогтоолоор “Хишиг Уул” хувьцаат компанийн нийслэлийн мэдлийн 34 хувь буюу 295 206 ширхэг хувьцааг нэг багц болгон 608,400,000 /Зургаан зуун найман сая дөрвөн зуун мянга/ төгрөгөөр нээлттэй дуудлага худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн.

Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Хишиг Уул” хувьцаат компанийн нийслэлийн мэдлийн 34 хувь буюу 295 206 ширхэг хувьцааг нэг багц болгон худалдах нээлттэй дуудлага худалдаанд хамгийн өндөр үнийн санал ирүүлсэн иргэн Я.Нэргүйтэй 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр 01/2024 дугаартай “Худалдах, худалдан авах тухай” гэрээ байгуулж, төлбөрийг хууль болон гэрээнд заасан хугацаанд бүрэн төлсөн тул Нийслэлийн Өмч хувьчлах комиссын 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн 02 дугаар тогтоолоор №02/2024 тоот “Өмчлөгчийн эрхийн гэрчилгээ”-г Монгол улсын иргэн Я.Нэргүйд шилжүүлэн олгохоор шийдвэрлэсэн болно.

Багануур дүүргийн нутаг дэвсгэрт байрлах “Хишиг Уул” хувьцаат компанийн нийслэлийн мэдлийн 34 хувь буюу 295 206 ширхэг хувьцааг тус компанийн хувьцаа эзэмшигч Монгол улсын иргэн Я.Нэргүйд хүлээлгэн өгч, акт үйлдэв.

Нийслэлийн өмч хувьчлах комиссын 02 дугаар тогтоолын дагуу “Хишиг уул” хувьцаат компанийн нийслэлийн мэдлийн 34 хувь буюу 295 206 ширхэг хувьцааг хүлээлгэн өгсөнөөр 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөс эхлэн тус компанийн хувьцаа эзэмшигч Монгол улсын иргэн Я.Нэргүй албан ёсоор эзэмших эрхтэй боллоо.


2024 оны санхүү байдлын тайланг ирүүлэн, нийслэлийн мэдлийн 34 хувьд ногдох хувьцааны ногдол ашгийг холбогдох дансанд төвлөрүүлэн тооцоог дуусгавар болгохыг “Хишиг уул” ХК-ийн захирал Я.Нэргүйд үүрэг болгож байна.

НИЙСЛЭЛИЙН МЭДЛИЙН 34 ХУВИЙН ХУВЬЦААГ

ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН :

ӨМЧИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

ӨМЧИЙН УДИРДЛАГА ЗОХИЦУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



С.СЭРЖЖАРГАЛ

С.ГОНЧИГСУМЛАЙ

ХҮЛЭЭН АВСАН:

ИРГЭН

Я.НЭРГҮЙ